



# ХИЧЭЭЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

<b>Хичээлийн нэр:</b>	Тогтвортой ба ногоон санхүү
<b>Хичээлийн индекс:</b>	LLL01
<b>Хичээлийн ангилал:</b>	Насан туршийн боловсрол
<b>Хичээлийн төрөл:</b>	Албан бус сургалт
<b>Хичээлийн багц цаг:</b>	2 ББц
	лекц 2 Бц
	семинар 0 Бц
	лаборатори 0 Бц
<b>Судлах улирал:</b>	Бүх улирал
<b>Цахим хичээл:</b>	Бүрэн цахим хичээл

<https://online.num.edu.mn/courses/course-v1:ToC+LLL01+2023/course/>

**Боловсруулсан:** ТоС Холбооны хамт олон

Байгууллага	Хүмүүс	Гарын үсэг
Тогтвортой санхүүжилтын холбоо	Д.Энхлин, ахлах менежер Б.Билэгсайхан, ахлах менежер Э.Ариунаа, менежер Д.Алтанзул, менежер Г.Янжинлхам, менежер Б.Халиунаа, мэргэжилтэн Ш.Анударь, мэргэжилтэн	

**Зөвшөөрсөн:**

Байгууллага	Хэлэлцүүлж зөвшөөрсөн хурлын огноо	Төслийн удирдагч	Гарын үсэг
ONE төслийн ажлын хэсэг	2024.05.13	О.Алтансүх	

**Баталсан:**

Хичээлийн тодорхойлолтыг 2024 оны 5-р сарын 13-ны өдрийн ТоС холбоо болон ONE төслийн хамтарсан хурлаар хэлэлцэж батлав.

Тамга



Co-funded by the  
Erasmus+ Programme  
of the European Union



## Төлөөлж холбогдох багшийн мэдээлэл:

---

Багшийн нэр, албан тушаал: Д. Алтанзул, Гишүүнчлэл, төсөл хариуцсан менежер  
Утас: 99227640  
Цахим шуудан: [altanzul@toc.mn](mailto:altanzul@toc.mn)  
Оффисын байршил: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Парк Плейс, 9 давхар, 904 тоот  
Зөвлөгөө өгөх гараг, цаг: Өдөр бүр 10:00 – 18:00  
Цахим хуудас: <http://toc.mn/>



## **ХИЧЭЭЛИЙН ЗАЛГАМЖ ХОЛБОО**

Энэ хичээлд урьдчилан үзсэн байх шаардлагатай хичээл байхгүй ч санхүү, тогтвортой байдлын талаар ерөнхий мэдлэгтэй байх нь хичээлийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

## **ХИЧЭЭЛИЙН ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ**

Энэхүү анхан шатны хичээлийн гол зорилго нь тогтвортой хөгжилд санхүүгийн салбарын оруулж буй хувь нэмэр болон тогтвортой санхүү салбарын гол оролцогчид, бүрэлдэхүүн хэсгүүд, үндсэн тогтолцоо, бодлого, зохицуулалтын талаар цогц ойлголт өгөхөд оршино. Уг хичээлээр оюутнууд Европын Холбоо болон Монгол дахь тогтвортой санхүүгийн хөгжлийн тоймыг суралцахаас гадна тогтвортой санхүүгийн үндсэн ойлголтууд, түүний хэрэгслүүдийн талаар техник мэдлэг чадвар эзэмших ач холбогдолтой.

## **ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА**

Тус хичээл нь дэлхий нийтэд эрчтэй хөгжиж буй тогтвортой санхүүгийн салбарын танилцуулга хичээл тул агуулгын хувьд цогц, хамрах хүрээ ихтэй байна. Эхний хэсэгт тогтвортой санхүүгийн танилцуулга, товч ойлголт, гол оролцогчид, байгууллагууд, байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийн удирдлага, санхүүгийн шийдвэр гаргах үйл явцад БОНЗ-ын эрсдэлийг хамааруулан авч үзэх тухай, санхүүгийн байгууллагуудын уур амьсгалын эрсдэлийн удирдлага гэх сэдвүүд багтсан ба хоёрдугаар хэсэгт тогтвортой хөгжлийг санхүүжүүлэх нь буюу таксономи, ногоон/тогтвортой зээл, бонд, хувьцаа, дижитал санхүү, Улсын ногоон банк ба тусгайлан зориулагдсан ногоон/тогтвортой холимог санхүүгийн механизм, БОНЗ-ын тайлагнал, ногоон оффис сэдвүүд, болон гуравдугаар хэсэгт тогтвортой санхүүгийн салбарт бодлого, журмын гүйцэтгэх үүрэг, Европын холбоо, Монгол Улс дахь бодлогын байр суурь ба чиг хандлага, хувийн байгууллагуудын баримталж буй тогтвортой санхүүгийн стандарт, зарчмууд, болон Монгол Улсын тогтвортой санхүүгийн салбарын үүсэл хөгжил ба ирээдүйн чиг хандлага гэсэн сэдвүүдээс бүрдсэн байна.

## **ХИЧЭЭЛЭЭР ЭЗЭМШИХ МЭДЛЭГ, ЧАДВАР, ДАДАЛ**

Сургалтын төгсгөлд тус хичээлийг амжилттай суралцсан оюутнууд тогтвортой санхүүгийн үндсэн ойлголтууд болон түүний санхүүгийн механизмуудын талаар мэдлэг олж авахаас гадна Европын Холбоо ба Монгол Улс дахь тогтвортой санхүүгийн хөгжил, хэрэгжилтийн талаар гүнзгий ойлголттой болно.

Тус хичээлийн хүрээнд оюутнууд тогтвортой хөгжил болон тогтвортой санхүүжилтийн талаарх мэдлэг ойлголт эзэмшсэнээр, тогтвортой санхүүжилтийн хэрэгжилт, үр дүн, арга хэрэгсэлд дүн шинжилгээ хийж, шийдэл гаргалгаа, шинэ санаа дэвшүүлэх чадваруудыг эзэмшинэ. Мөн түүнчлэн, тогтвортой санхүүжилтээр дамжуулан хэрхэн тогтвортой хөгжил болон ТХЗ-уудад хувь нэмэр оруулах, илүү тогтвортой, эрх тэгш нийгэм рүү шилжихэд санхүүгийн салбарын үүрэг, хариуцлагын талаар сайтар эргэцүүлэн бодохыг дэмжиж, онолын мэдлэгийг практикт ашиглах дадал чадварыг суралцана.

Улмаар тогтвортой хөгжил, уур амьсгалын өөрчлөлт, эдийн засаг, бизнесийн салбарт карьер хөөж буй төгсөгчдөд ажлын талбарт гарахад нь чухал үр өгөөжтэй.

## **ЗААХ АРГА БАРИЛ**

Сургах болон сурах үйл явц нь шавь төвт сургалтын арга барилд тулгуурлах ба сэдэв бүрийн видео лекцүүдийг үзэн бататгах асуулгад хариулах хэлбэрээр явагдана. Агуулга (content based), асуудал (problem based), асуулгад суурилсан (quiz based) сургалтын арга хэлбэр голлоно.

## **ХИЧЭЭЛИЙН ДААЛГАВАР**

Видео хичээл бүрийн төгсгөлд тухайн сэдвийн ойлголтыг бататгах түлхүүр асуултууд байгаа бөгөөд суралцагчид түүнд хариулснаар өөрийн мэдлэгийг бэхжүүлнэ.



Үйл ажиллагаа	Суралцах үр дүн	Үнэлгээ	Ачаалал (цаг)
<b>Бие даасан ажил</b>			
Видео хичээлүүд	Тогтвортой санхүүтэй холбоотой ойлголтууд, хамрах хүрээ, хэрэгцээ шаардлага, болон төрөл бүрийн нөхцөл, саад бэрхшээл; Европын Холбооба Монголын Тогтвортой Санхүүгийн хөгжлийн талаарх гүнзгий мэдлэгтэй болох Сурагчдыг хүссэн цаг, нөхцөлдөө хичээлээ үзэж суралцах боломжоор хангаж байгаа нь мөн оюутнуудын биеэ даасан байдал, цагийн зөв хуваарилалтыг дэмжихэд үр нөлөөтэй.	Бүх видео хичээлийг үзэж бүх асуулгуудад хариулах	4-6 цаг

### ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Асуулгууд	Видео хичээл бүрийн төгсгөлд оюутнуудаас 5 асуулт бүхий асуулгаар хичээлийг бататгана. Асуултууд нь сургалтын видео дээр хэлэлцсэн гол санаа, үзэл баримтлалын талаар оюутнуудын ойлголтыг үнэлэх ба эдгээр асуулгуудын зөв хариулсныг хувьд шилжүүлэн хичээлийн үнэлгээг гаргана.		
Үнэлгээний систем	95-100	A	4.0
	90-94	A-	3.6
	85-89	B	3.1
	80-84	B-	2.7
	75-79	C	2.3
	70-74	C-	1.9
	65-69	D	1.4
	60-64	D-	1.0
	0-59	F	0.0

### ХИЧЭЭЛД АШИГЛАХ НОМ, СУРАХ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Үндсэн сурах бичиг:

1. С.Дашдорж ба бусад, (2019) “Тогтвортой санхүү”, редакторууд Д.Оюунцэцэг, С.Алтанцэцэг ба С.Дашдорж, анхны хэвлэл, Улаанбаатар, хуудас 379, ISBN: 978-9919-21-468-5, Монгол хэл
2. Монгол Улсын Үндэсний тогтвортой санхүүжилтийн замын зураг

Нэмэлтээр унших ном, материал:

1. Г.Ганзориг, Б.Бат, Д.Гансүлд, Т.Эрдэнэчулуун, Б.Нарантунгалаг, Д. Түвшинжаргал, Н.Одмаа ба Б.Цогт-Эрдэнэ (2018) Ногоон эдийн засаг ба загварчлал, сурах бичиг анхны хэвлэл., Linograph хэвлэлийн газар, Улаанбаатар, Монгол улс, ISBN: 978-99978-2-564-3, [https://www.researchgate.net/publication/329999530\\_Nogoon\\_edijn\\_zasag\\_ba\\_z\\_agvarclal](https://www.researchgate.net/publication/329999530_Nogoon_edijn_zasag_ba_z_agvarclal)
2. Монголын Ногоон Таксономи
3. Тогтвортой хөгжлийн зорилтын санхүүжилтийн таксономи
4. Текстилийн салбарын ногоон зээлийн шалгуур
5. Банкнуудын тогтвортой хөгжил, БОНЗ-ын тайлангууд



## ХИЧЭЭЛИЙН СЭДЭВЧИЛСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ

7 хоног	Хичээлийн сэдэв	Видео
1	Тогтвортой санхүүгийн танилцуулга, гол хүчин зүйлүүд, ба ирээдүйн чиг хандлага	18:34
2	Тогтвортой хөгжлийн асуудлуудад санхүүгийн салбарын гүйцэтгэх үүрэг ба гол тоглогчид, байгууллагууд, бүрэлдэхүүн хэсгүүд	20:03
3	Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийг санхүүгийн шийдвэр гаргах үйл явцад хамааруулан авч үзэх нь	24:22
4	Санхүүгийн байгууллагуудын уур амьсгалын эрсдэлийн удирдлага	22:57
5	Тогтвортой байдлыг санхүүжүүлэх нь буюу таксономи: Европыг Холбооны болон Монгол Улсын таксономи	7:38
6	Ногоон /тогтвортой зээл, жишээ	15:19
7	Ногоон /тогтвортой бондууд, жишээ	23:33
8	Ногоон /тогтвортой хувьцаа, жишээ	7:37
9	Ногоон /тогтвортой дижитал санхүү	18:07
10	Улсын ногоон банк ба тусгайлан зориулагдсан ногоон/тогтвортой холимог санхүүгийн механизмууд	13:56
11	БОНЗ-ын тайлагнал: TCFD, GRI, ба бусад уур амьсгалтай холбоотой тайлагналын хэрэгслүүд	23:27
12	Ногоон, хүртээмжтэй оффис	15:18
13	Тогтвортой санхүүгийн салбарт бодлого, журмын гүйцэтгэх үүрэг дэлхий дахинд болон Европын Холбоонд	32:15
14	Монголд Тогтвортой санхүүгийн салбарт бодлого, журмын гүйцэтгэх үүрэг	13:34
15	Хувийн байгууллагуудын баримталж буй тогтвортой санхүүгийн стандарт, зарчмууд	40:11
16	Монгол Улсын тогтвортой санхүүгийн салбарын үүсэл хөгжил ба ирээдүйн чиг хандлага	20:16